

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2015 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2015.11.20

Улаанбаатар хот

НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тайлант хугацаанд Хорооны хуралдаанаар 72 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 8 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 442 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсанаас хойш буюу 2006 оны тайлант жилээс эхлэн ББСБ-уудын тооны өөрчлөлтийг харуулбал:

Хүснэгт 1

д/д	Тайлант хугацаа	ББСБ-ын тоо	Үүнээс:		
			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй	Гадаадын хөрөнгө оруулалттай	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлж буй
1	2006 он	139	-	-	-
2	2007 он	137	-	-	-
3	2008 он	132	23	11	-
4	2009 он	177	27	9	47
5	2010 он	182	26	15	48
6	2011 он	195	23	17	39
7	2012 он	212	24	17	38
8	2013 он	263	31	19	41
9	2014 он	378	40	23	53
10	2015 оны III улирал	442	51	25	52

Хорооноос ББСБ-уудын тусгай зөвшөөрлийн зохицуулалтын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

д/д	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	-	-	139
2	2007 он	10	12	-	-	137
3	2008 он	10	15	-	-	132
4	2009 он	56	11	15	9	177
5	2010 он	20	15	20	7	182
6	2011 он	32	19	14	8	195
7	2012 он	23	6	4	2	212
8	2013 он	54	3	3	1	263
9	2014 онд	120	5	5	1	378
10	2015 оны III улирал	72	8	5	3	442

2015 оны гуравдугаар улирлын байдлаар 72 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон бөгөөд тэдгээр компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгө нь 30.6 тэрбум төгрөг байна.

Мөн Хорооны хуралдаанаар 5 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 8 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгон, 3 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх арга хэмжээ авсан байна.

Зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тус бүр хоёр компанид нэмж олгох, итгэлцэлийн үйлчилгээний зөвшөөрөл, гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрлийг тус бүр гурван компанид нэмж олгох, нэг компанийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх, мөн нэг компанийн гадаад валютын арилжаа эрхлэх зөвшөөрлийг тус тус хүчингүй болгох арга хэмжээ авсан байна.

ББСБ-ын тооны өөрчлөлтийг үзүүлбэл:

График 1



Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж байгаа байдлаар нь ББСБ-уудыг ангилвал:

Хүснэгт 3

д/д	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын давхардсан тоо ба өсөлт		Өөрчлөлт	
		2014 оны III улирал	2015 оны III улирал	тоо	хувь
	Нийт ББСБ	351	442	91	126.1
1	Гадаад валютын арилжаа эрхэлдэг	124	132	8	106.5
	<i>Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг</i>	53	52	(1)	(101.9)
2	Зээл	296	380	84	128.3
3	Факторингийн үйлчилгээ	16	17	1	106.3
4	Төлбөрийн баталгаа гаргах	11	13	2	118.2
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0	-	-
6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	6	-	100.0
7	Итгэлцлийн үйлчилгээ	25	26	1	104.4
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2	-	100.0
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	27	26	1	104.0

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, зах зээлийн эрэлтийг дагаж энэхүү салбарт оролцогчдын тоо 26.1 хувиар буюу 91 компаниар нэмэгдэж, зээлийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 28.3 хувь буюу 84 компаниар, гадаад валютын арилжаа эрхлэгчид 6,5 хувиар буюу 8 компаниар нэмэгдсэн нь хамгийн их хэрэгцээтэй үйлчилгээ болохыг харуулж байна.

2015 оны гуравдугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 442 ББСБ-ын 30 хувь буюу 132 компани гадаад валютын арилжаа эрхэлж байгаагаас 11.8 хувь буюу 52 компани нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлж байна.

Мөн нийт ББСБ-ын 86.1 хувь буюу 380 компани зээлийн үйл ажиллагаа, 5.9 хувь буюу 26 компани хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 5.9 хувь буюу 26 компани итгэлцлийн үйлчилгээ, 3.8 хувь буюу 17 компани факторингийн үйлчилгээ, 3.0 хувь буюу 13 компани төлбөрийн баталгаа гаргах, 1.3 хувь буюу 6 компани цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.5 хувь буюу 2 компани богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхэлж байна.

Тайлант хугацаанд эхлэлтийн санхүүгийн тайлангаар 17 ББСБ, өмнөх үеүдийн санхүүгийн тайлангаар 7 ББСБ нэгтгэлд хамрагдсан байна.

2015 оны гуравдугаар улирлын тайлан ирүүлбэл зохих нийт 442 ББСБ-аас 419 ББСБ буюу 94.8 хувь нь тайлангаа зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж тайлангийн нэгтгэлд хамруулсан байна.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Ерөнхий статистик үзүүлэлтүүд:

Тайлант хугацааны голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж харуулбал: Үүнд:

Хүснэгт 4

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны III улирал	2015 оны III улирал	Өөрчлөлт /+/, -/	
				дүн	хувь
1	ББСБ-ын тоо	351	442	91	126,0
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	863	901	38	104,4
3	Ажиллагсадын тоо	1,632	1950	318	119,5
4	Салбар нэгжийн тоо	92	99	7	107,6
5	Харилцагчдын тоо	518,489	554,901	36,412	107,0
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	489,991,180.9	581,869,478.1	91,878,297.2	118,7
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>2.7</i>	<i>3.0</i>		<i>0.30</i>
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	293,922,125.6	383,365,773.1	89,443,647.5	130,4
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>2.0</i>	<i>3.3</i>		<i>1.3</i>
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	301,294,304.1	393,071,528.8	91,777,224.7	130,5
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>24.9</i>	<i>15.8</i>		<i>(9.1)</i>
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	234,374,720.9	298,281,559.4	63,906,838.5	127,3
<i>Банкны салбартай харьцуулахад /хувь/</i>		<i>44.9</i>	<i>53,5</i>		<i>8.6</i>
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	24,941,126.0	31,921,182.1	6,980,056.1	128,1
11	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл /мянган төгрөгөөр/	127,862,015.5	124,825,941.2	(3,036,074.3)	(102,4)
	Үүнээс: Богино хугацаат зээл/мянган төгрөгөөр/	72,160,008.1	61,825,941.2	(10,334,066.9)	(114,3)
	Урт хугацаат зээл /мянган төгрөгөөр/	55,702,007.4	63,270,419.0	7,568,411.6	113,6
12	Төслийн зээлийн санхүүжилт /мянган төгрөгөөр/	11,829,385.9	14,560,689.2	2,731,303.3	123,1
13	Нийт орлого /мянган төгрөгөөр/	99,398,778.1	115,496,157.2	16,097,379.1	116,2
14	Нийт зардал /мянган төгрөгөөр/	72,446,935.3	82,320,433.3	9,873,497.9	113,6
15	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	26,705,079.5	33,342,357.5	6,637,278.0	124,8

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 581.9 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.0 хувьтай, зээлийн өрийн үлдэгдэл 383.3 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.3 хувьтай, эзэмшигчдийн өмч 393.1 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 15.8 хувьтай, дүрмийн сан 298.3 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 53,5 хувьтай тус тус тэнцэж байна.

ББСБ-уудын нийт актив өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтөд эзэмшигчдийн өмчийн дүн 91.8 тэрбум төгрөгөөр буюу 30.5 хувиар, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 63.9 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Мөн өр төлбөрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өр 6.9 тэрбум төгрөгөөр буюу 28.1 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 2.7 тэрбум төгрөгөөр буюу 23.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн эдгээр өөрчлөлт, өсөлттэй уялдан нийт зээлийн хэмжээ 89.4 тэрбум төгрөгөөр буюу 30.4 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 91 компаниар буюу 26.1 хувиар, хувьцаа эзэмшигчдийн тоо 38-аар буюу 38.0 хувиар нэмэгдсэн байна. Салбарт ажиллагсдын тоо 318 хүнээр нэмэгдэж 1950-д хүрсэн байна.

Улсын хэмжээнд 442 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 88.5 хувь буюу 391 нь УБ хотод, 11.5 хувь буюу 51 нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Говь-Алтай, Увс аймгуудад ББСБ байгуулагдаагүй байна.

ББСБ-уудын байршлыг үзүүлбэл:

график 2



2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

Тайлант улиралд орон нутагт төвтэй 51 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.5 хувийг, тэдгээрийн актив нь салбарын активын 2.7 хувийг, зээл нь 2,1 хувийг, эзэмшигчдийн өмч нь 3.2 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2.7 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 5

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны III улирал	2015 оны III улирал	Өсөлт +/-, бууралт -/-
	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	40	51	11
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	11.4	11.5	0.1
A	Нийт актив /мянган төгрөгөөр/	9,786,548.5	15,773,582.9	5,987,034.4

<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>		2.0	2.7	0.7
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	7,369,235.7	12,060,810.7	4,691,575
<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>		2.5	2.1	0.4
	Чанаргүй зээл /мянган төгрөгөөр /2,1 1,9/	166,382.2	439,549.8	273,167.6
	<i>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь</i>	2.1	1.4	(0,7)
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	9,054,795.1	12,625,312.2	3,570,517.1
<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>		3.0	3.2	0.2
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	6,329,951.8	8,198,179.5	1,868,227.7
<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>		2.7	2.7	0.0

Хорооноос орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх талаар олон нийтэд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөөг өгч ажиллаж байгаагийн дүнд сүүлийн жилүүдэд орон нутагт үйл ажиллагаа явуулах ББСБ-ын тоо нэмэгдсээр байна.

2012 оны жилийн эцэст 24 ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж байсан бол 2013 оны жилийн эцэст 31, 2014 оны жилийн эцэст 40, 2015 оны эхний 9 сарын байдлаар 51 ББСБ орон нутагт үйл ажиллагаа явуулж жил тутам 28 хувиар тооны хувьд өссөн үзүүлэлттэй байна.

2.3 Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

Тайлант хугацааны эцэст гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 25 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 5.6 хувийг, тэдгээрийн актив нь ББСБ-ын нийт активын 15.3 хувийг, зээлийн үлдэгдэл нь нийт ББСБ-уудын зээлийн 18.1 хувийг, эзэмшигчдийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн 13.3 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн 13.03 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны III улирал	2015 оны III улирал	Өсөлт /+/, бууралт /-/ %
	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	24	25	1
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	6.8	5.6	(-1.2)
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	70,888,798.8	88,937,047.9	18,048,249.1
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	14.5	15.3	0.8
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	43,983,707.3	69,592,669.2	25,608,991.9
	Үүнээс: Чанаргүй зээл /мянган төгрөгөөр/	2,553,852.6	7,712,568.0	5,158,715.4
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	15.0	18.1	3.1
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	39,550,293.4	52,254,599.7	12,704,306.3
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	13.1	13.3	0.2
Г	Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/	30,910,829.4	38,885,199.9	7,974,370.5
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	13.19	13.03	(0.16)

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяалаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 10, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 6, Хонгконгийн хөрөнгө оруулалттай 2, АНУ, ОХУ, Люксембург, Малайз, Англи, Франц, Швейцарийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

2.4 Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ББСБ:

Тайлант оны эхний хагас жилд нийт 72 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосны 6.9 хувь буюу 5 компанид банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

Мөн өмнө нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 3 компанид гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нэмж олгосон ба гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээсэн болон хүчингүй болгосон тус бүр 1 байна.

Тайлант хугацааны эцэст Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 442 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүний 30 хувь буюу 132 компани гадаад валютын арилжаа эрхэлж байгаагаас 11.8 хувь буюу 52 компани нь гадаад валютын арилжааг дагнан эрхэлж байна.

Гадаад валютын арилжааг дагнан эрхэлж буй ББСБ-уудын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг харуулвал:

Хүснэгт 7

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны III улирал	2015 оны III улирал	Өсөлт +/-, бууралт -/-
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагааг эрхэлж буй ББСБ-ын тоо	53	52	2
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	<i>15.1</i>	<i>11,7</i>	<i>(3.4)</i>
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	14,461,986.0	9,574,808.1	(4,887,178,0)
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	<i>2,9</i>	<i>1,6</i>	<i>(1,3)</i>
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	11,263,138.7	9,514,116,9	(2,235,588.7)
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	<i>3,7</i>	<i>3,2</i>	<i>(0.5)</i>
В	Нийт дүрмийн сан /мянган төгрөгөөр/	9,546,742.4	9,027,550.0	(630,692.4)
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	<i>4,1</i>	<i>3,0</i>	<i>(1.1)</i>

ГУРАВ. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант хугацааны ББСБ-уудын активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 8

д/д	ХӨРӨНГӨ	2014.9.30		2015.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
А	Эргэлтийн хөрөнгө	473,360,973.1	96.6	562,588,577.1	96.7	89,227,603.1	118.8
1	Мөнгөн хөрөнгө	145,301,129.9	29.6	147,632,642.7	25.4	2,331,512.8	101.6
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	10,874,907.2	2.2	11,385,945.1	2.0	511,037.9	104.7
3	Нийт зээл	293,922,125.6	60.0	383,365,773.9	66.0	89,443,648.3	130.4
	(Зээлийн эрсдлийн сан)	12,414,972.4	2.5	23,371,596.1	4.0	10,956,623.7	188.2
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	8,235.6	0	0	-	(8,235.6)	(100.0)
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0	0.0	-	0.0	0
5	Нийт факторингийн тооцооны авлага	74,800.0	0.02	90,000.0	0.02	15,000.0	120.3
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	1,500.0	0	30,000.0	0.01	28,500.0	1900.0
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	1,569,183.4	0.3	2,209,693.1	0.4	640,509.7	140.8
7	Бусад хөрөнгө	34,027,063.7	6.9	41,306,118.3	7.1	7,279,054.6	121.4
Б	Эргэлтийн бус хөрөнгө /цэврээр/	16,630,207.9	3.4	19,280,901.9	3.3	2,650,694.0	116.0

9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	21,166,505.8	4.3	24,743,715.2	4.3	3,577,209.4	117.0
	(Хуримтлагдсан элэгдэл)	4,536,298.3	0.9	5,462,813.3	0.9	926,514.1	120.4
НИЙТ ХӨРӨНГӨ		489,991,180.9	100.0	581,869,479.0	100.0	91,878,298.1	118.7


2014 оны гуравдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 351 ББСБ 489.9 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байсан ба активын өсөлт нь өмнөх оныхоо мөн үеэс 145,9 тэрбум төгрөгөөр буюу 42.4 хувиар өссөн бол тайлант хугацаанд 442 ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 581.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 91.8 тэрбум төгрөгөөр буюу 18,7 хувиар өссөн байна.

Активын өсөлт, бүтцийг өмнөх онуудтай харьцуулж харуулбал:

График 3



График 4



3.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 9

д/д	Ангилал	2014.9.30		2015.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	256,784,754.2	87.4	326,267,436.3	85.1	69,482,682.0	127.0
2	Хугацаа хэтэрсэн	19,304,909.1	6.6	22,151,882.0	5.8	8,846,972.9	145.8
3	Чанаргүй зээл. Үүнээс	17,832,462.3	6.1	34,946,455.6	9.1	17,113,993.3	195.9
	Хэвийн бус	5,099,022.6	1.7	10,434,289.0	2.7	5,335,266.4	204.0
	Эргэлзээтэй	6,837,220.0	2.3	10,622,391.0	2.7	3,785,171.0	155.3
	Муу	5,896,219.7	2.0	13,889,775.6	3.6	7,993,555.9	235.5

4	(Зээлийн эрсдэлийн сан)	12,414,972.4	4.2	23,371,596.1	6.1	10,956,623.7	188.2
Нийт зээл		293,922,125.6	100.0	383,365,773.9	100.0	89,443,648.3	130.4
5	Үүнээс: Төгрөгөөр олгосон зээл	254,375,735.1	86.5	340,401,056.5	88.8	86,025,321.4	133.8
6	Гадаад валютаар олгосон зээл	39,546,390.6	13.5	42,964,717.4	11.2	3,418,326.8	108.6

Тайлант үеийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, нийт зээлийн хэмжээ 89.4 тэрбум төгрөгөөр буюу 30.4 хувиар өссөн байна.

Зээлийн бүтцийн хувьд нийт зээлд төгрөгөөр олгосон зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өсч, гадаад валютаар олгосон зээлийн эзлэх хувь мөн хэмжээгээр буурсан байна. Төгрөгөөр олгосон зээл өмнөх оны мөн үеэс 86.0 тэрбум төгрөгөөр буюу 33.8 хувиар, гадаад валютаар олгосон зээл 3.4 тэрбум төгрөгөөр буюу 8.6 хувиар тус тус өссөн байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн ангилалын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдсэн, нийт чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.1 тэрбум төгрөгөөр буюу 95.9 хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн хэмжээ, түүний дотор муу зээлийн хэмжээ 2 дахин нэмэгдсэнтэй холбогдон зээлийн эрсдлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеэс 10.9 тэрбум төгрөгөөр буюу 88.2 хувиар өссөн байна.

ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал:

График 5





График 5.1




Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 380 ББСБ -ууд нийт 383,365,773.9 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна. Зээлийн өрийн үлдэгдлийн 9.1 хувь нь буюу 34,946,455.6 мянган төгрөгийн чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл байна.

3.3 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 442 ББСБ-аас 86.0 хувь буюу 380 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба эдгээр компаниудын зээлийн сарын хамгийн дээд хүү 10.0 хувь, хамгийн бага хүү 0.1 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

График 6



3.4 Активын бусад үзүүлэлтийн талаар:

Богино хугацаат хөрөнгө оруулалтын /цэврээр/ дансны үлдэгдэлд 11,385,945.1 мянган төгрөг байна. Үүнд:

Хүснэгт 10

д/д	Богино хугацаат хөрөнгө оруулалтын төрөл	Хэмжээ /мянган төгрөг/	Богино хугацаат хөрөнгө оруулалтад эзлэх хувь
1	Арилжааны үнэт цаас	10,206,335.5	89,6
2	Хөрөнгө оруулалтын үнэт цаас	1,179,609.6	10,4
3	Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл, хямдруулалт	0.00	0,0
	НИЙТ	11,385,945.1	100,0

Факторингийн тооцооны авлагын 66.6 хувь нь буюу 60,000.0 мянган төгрөг нь хэвийн, 33.4 хувь нь буюу 30,000.0 мянган төгрөг нь муу авлагад ангилагдан 30,000.0 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 442 ББСБ-д 24,743,715.2 мянган төгрөгийн үндсэн ба биет бус хөрөнгө бүртгэгдсэн ба тэдгээрт 5,462,813.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцон нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 11


д/д	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2014.9.30		2015.9.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь

		/мян.төг/					
A	Нийт өр төлбөр	171,514,859.6	35.0	175,312,775.1	30,1	3,797,915.5	102,2
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	24,941,126.0	5.1	31,921,182.1	5,5	6,980,056.1	128,0
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	127,862,015.5	26.1	124,825,941.2	21,4	(3,036,074.3)	(2,4)
3	Бусад эх үүсвэр	5,046,932.1	1.0	2,491,220.1	0,40	(2,555,712.0)	(50,6)
	<i>Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр</i>	53,517.2	0.01	0,00	-	(53,517.2)	(100,0)
	<i>Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг</i>	4,993,415.0	1.0	355,055.1	0,1	(4,638,359.9)	(92,9)
	<i>Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг</i>	-	-	2,136,165.0	0,3	2,136,164.9	100,0
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	1,835,400.0	0.4	1, 513,742.5	0,3	(321,657.5)	(17,5)
5	Төслийн зээлийн санхүүжилт	11,829,386.0	2.4	14,560,689.1	2,5	2,731,303.2	123,1
6	Бусад өр төлбөр	17,182,017.2	3.5	13,485,175.1	2,3	(3,696,842.0)	(21,5)
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	3,492,243.5	0,7	4,249,348.5	0,73	747,105	121,7
	Бусад пассив	13,689,773.7	2,8	9,235,826.6	1,59	(4,453,947.05)	(32,5)
	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	-	-	-	-	-	-
B	Эзэмшигчдийн өмч	301,294,304.1	61,5	393,071,528.7	67,55	90,777,224.6	130,1
7	Хувьцаат капитал	234,374,720.9	47,8	298,281,559.4	51,26	63,906,838.5	127,3
8	Бусад өмч	7,848,251.1	1,6	9,364,477.9	1,61	1,516,226.8	119,3
9	Сангууд	299,947.0	0,1	337,276.7	0,06	37,329.7	112,4
10	Хуримтлагдсан ашиг/алдагдал	56,979,175.1	11,6	83,686,802.1	14,38	26,707,627.0	146,9
11	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	1,792,209.9	0,4	1,401,412.6	0,24	(390,797.3)	(21,8)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		489,991,180.9	100,0	581,869,479.0	100,0	91,878,298.1	118.7

2014 оны гуравдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөлтэй 351 ББСБ -ийн хөрөнгийн эх үүсвэр 489,9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоо мөн үеэс 145,9 тэрбум төгрөгөөр буюу 42.4 хувиар өсч байсан бол тайлант хугацаанд 442 ББСБ-уудын хөрөнгийн эх үүсвэр 581.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 91,9 тэрбум төгрөгөөр буюу 18,7 хувиар өссөн байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын хэмжээг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.


График7



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын төслийн зээлийн санхүүжилтийн хэмжээ 23,1 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд шинээр байгуулагдсан банк бус санхүүгийн байгууллагуудын тоо өмнөх онтой харьцуулахад 26,1 хувийн өсөлттэй байгаа бөгөөд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр өсөхөд голлох нөлөө үзүүлж байна.

График 8



2015 оны гуравдугаар улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй 26 ББСБ байна.

Бусад нэр бүхий 22 ББСБ 31,861,182.1 мянган төгрөгийг итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн нь салбарын өр төлбөрийн 16.9 хувьтай тэнцэж байна.

Нийт ББСБ-ын 5.9 хувийг эзлэх эдгээр 26 компанийн актив нь салбарын нийт активын 32.2 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь салбарын нийт эзэмшигчийн өмчийн 28.9 хувийг тус тус эзэлж байна.

2015 оны гуравдугаар улирлын байдлаар Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 ББСБ байна. Бусад нэр бүхий 4 ББСБ нь 2,491,220.1 мянган төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өртэй байна.

Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 6 ББСБ-ын актив 21,567,474.8 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 3.7 хувийг, эзэмшигчийн өмчийн дүн 15,726,850.4 мянган төгрөг байгаа нь салбарын мөн үзүүлэлтийн 4.0 хувийг, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өр 2,491,220.1 мянган төгрөг нь салбарын нийт өрийн 1.3 хувьтай тэнцэж байна.

Тайлант хугацаанд Хорооны зөвшөөрөлтэйгөөр 2 ББСБ нийт 1,513,742.5 мянган төгрөгийн хаалттай өрийн бичгийг гаргасан байна.

2015 оны гуравдугаар улирлын байдлаар 8 ББСБ 1,401,412.6 мянган төгрөгийн хоёрдогч өглөг бүртгэгдсэн байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант улиралд ББСБ-уудын нийт орлого өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

Хүснэгт 12

д/д	Үзүүлэлт	2014.9.30		2015.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	Хүүгийн орлого	65,510,258.9	65.9	85,610,983.7	74.1	20,100,724.8	130.7

	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	62,582,339.2	63.0	79,545,588.9	68.9	16,963,249.7	127.1
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	2,231,978.8	2.2	5,540,153.3	4.8	3,308,174.5	248.2
	Үнэт цаасны хүүгийн орлого	-	-	-	-	-	-
	Бусад хүүгийн орлого	695,940.8	0.7	525,241.5	0.5	(170,699.2)	(24.5)
2	Хүүгийн бус орлого	32,878,580.2	33.1	28,536,332.0	24.7	(4,342,248.2)	(13.2)
3	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	932,131.0	0.9	1,348,841.4	1.2	416,710.4	144.7
4	Ердийн бус орлого	77,808.0	0.1	-	-	(77,808.0)	(100.0)
	Нийт орлого	99,398,778.1	100.0	115,496,157.2	100.0	16,097,379.1	116.2

ББСБ-уудын үндсэн үйл ажиллагааны буюу хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 30.7 хувиар өсөж, нийт орлогын дүнд эзлэх хувийн жин нь 8.2 хувиар нэмэгдэж 74.1 хувийг, үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт орлогийн дүнд эзлэх хувийн жин 1.2 хувиар нэмэгдэж, 44.7 хувийг тус тус эзэлж байна.

Харин хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар буурч, нийт орлогын дүнд эзлэх хувийн жин нь 8.4 хувиар багасч 24.7 хувийг эзэлж байна.

Хүүгийн бус орлого дараах үндсэн бүтэцтэй байна.

Хүснэгт 13

д/д	Үзүүлэлт	2014.9.30		2015.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	Арилжааны орлого	3,401,341.2	10.3	2,343,716.6	8.21	(1,057,624.6)	(31.1)
1.1	Гадаад валютын арилжааны орлого	3,242,241.0	9.9	2,343,715.6	8.21	(898,525.4)	(27.7)
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	159,100.1	0.5	0.00	0	(159,100.1)	(100.0)
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	23,915,943.2	72.7	21,222,903.2	74.4	(2,693,040.0)	(11.3)
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	22,783,917.5	69.3	21,222,903.2	74.4	(2,693,040.0)	(11.3)
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	1,132,025.7	3.4	0.00	0	(1,132,025.7)	(100.0)
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	5,647,568.5	17.2	4,969,712.3	17.4	(677,856.2)	(12.0)
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	789.5	0.0	0.00	0	(789.5)	100.0)
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	8,287.4	0.0	3,120.1	0.01	(5,167.3)	(62.3)
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	665,532.7	2.0	485,767.8	1.7	(179,764.9)	(27.0)
3.4	Картын үйлчилгээний орлого	1,510.0	0.0	750.0	0.003	(760.0)	(50.3)
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	517,213.2	1.6	539,538.4	1.9	22,325.2	4.3
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	4,023,955.0	12.2	3,275,903.8	11.5	(748,051.2)	(18.5)
3.7	Бусад	431,854.0	1.3	664,632.2	1.3	232,778.2	53.9
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	32,878,580.2	100.0	28,536,332.0	100.0	(4,342,248.1)	(13.2)

2014 оны гуравдугаар улирлын байдлаар нийт хүүгийн бус орлогын 9.9 хувийг гадаад валютын арилжааны орлого, 72.7 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 17.2 хувийг бусад

санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол тайлант улиралд нийт хүүгийн бус орлогын 8.2 хувийг гадаад валютын арилжааны орлого, 74.4 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 17.4 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

Хүснэгт 14

д/д	Үзүүлэлт	2014.9.30		2015.9.30		Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	Хүүгийн зардал	9,556,215.4	13.2	11,060,379.1	1.3	1,504,163.7	115.7
2	Хүүгийн бус зардал	51,443,992.8	71.0	55,661,603.7	67.6	4,217,610.9	108.2
3	Болзошгүй эрсдэлийн зардал	7,385,617.9	10.2	10,604,801.3	12.9	3,219,183.4	43.6
4	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	720,994.8	1.0	648,165.3	0.8	(72,829.5)	(10.1)
5	Ердийн бус зардал	1,018.2	0.0	11.5	0.0	(1,006.6)	(98.8)
6	Орлогын татварын зардал	3,339,096.2	4.6	4,345,472.4	5.3	1,006,376.2	130.1
	НИЙТ ЗАРДАЛ	72,446,935.3	100.0	82,320,433.3	100.0	9,873,498.0	113.6

Тайлант хугацаанд нийт зардал өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар, үүний дотор хүүгийн зардал 15.7 хувиар, хүүгийн бус зардал 8.2 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 43.6 хувиар, орлогын татварын зардал 30.1 хувиар тус тус өсөж, үндсэн бус үйл ажиллагааны зардал 10.1 хувиар, ердийн бус зардал 98.8 хувиар тус тус буурсан байна.


Тайлант хугацаанд нийт 33,184,596.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 24.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 15

д/д	Үзүүлэлт	2014.9.30	2015.9.30	Өөрчлөлт	
		Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Хувь
1	Нийт орлого	99,398,778.1	115,496,157.2	16,097,379.1	116.1
2	Нийт зардал	72,446,935.3	82,320,433.3	9,873,498.0	113.6
	Татварын дараах цэвэр ашиг	26,705,079.5	33,184,596.4	6,479,516.9	124.2

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж харуулбал:

График 9



ЗУРГАА. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант улиралд Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна:

Хүснэгт 16

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Нийт ББСБ-д эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	349	78.9
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	54	12.2
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	28	6.3
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	7	1.6
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.4
6	5 ба дээш зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	0.4
	НИЙТ	442	100.0

ББСБ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт дараах байдалтай байна:

- нийт өөрийн хөрөнгө 394,053,739.0 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 467,147,569.2 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага 83,5 хувиар, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлага 84.4 хувиар, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 10 хувиас доошгүй байх шаардлага 69,5 хувиар;
- нийт түргэн борлогдох актив 112,209,008.3 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 169,930,965.8 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлага 108.0 хувиар;
- валютын дансны цэвэр зөрүү 6,796,581.7 мянган төгрөг, тухайн валютаар өөрийн хөрөнгө 393,810,386.0 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 1.20 хувиар;
- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 31,921,182.1 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 393,653,297.0 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 80 хувиас ихгүй байх шаардлага 8,1 хувиар;
- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 3,100,574.9 мянган төгрөг, нийт актив 581,869,479.9 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлага 1.6 хувиар;
- гаргасан хаалттай өрийн бичгийн үлдэгдэл 1,513,742.5 мянган төгрөг, өөрийн хөрөнгө 392,633,087.9 мянган төгрөг байгаагаас хаалттай өрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 50 хувиас ихгүй байх шаардлага 50 хувиар тус тус биелэсэн байна.

Харин зээлийн эрсдэлийн санг 24,444,696.7 мянган төгрөгөөр байгуулсан байна.

ДОЛОО. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1. Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан, зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 380 ББСБ-ын 67.4 хувь буюу 256 ББСБ энэ үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Хорооны 2009 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-д заасны дагуу нийт ББСБ-ын 61.2 хувь буюу 259 ББСБ дээрх

хуулийн хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилон ажиллуулж байна.

3. Энэ онд нийт 371 ББСБ-аас 350,365.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэхээс 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 288 ББСБ 284,487.0 мянган төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төвлөрүүлсэн. Биелэлт 81.2 хувьтай байна.

4. Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үүргийг оны эхэнд үйл ажиллагаа эрхэлж байсан 378 ББСБ -ын 47.4 хувь буюу 179 ББСБ хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ

1. 2015 оны гуравдугаар улиралд нийт ББСБ-ын 94.8 хувь буюу 416 ББСБ санхүүгийн тайлангаа ирүүлж нэгтгэлд хамруулсан ба нэр бүхий 16 ББСБ эхлэлийн тайлан тэнцлийн, 7 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлийн үзүүлэлтээр хамрагдсан байна.

2. Тайлант хугацаанд ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 91 компаниар буюу 26.0 хувиар, хувьцаа эзэмшигчдийн тоо 38-аар буюу 4.4 хувиар нэмэгдсэн байна. Салбарт ажиллагсдын тоо 318 хүнээр нэмэгдэж 1950-д хүрч, харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 36,412-оор буюу 7.0 хувиар өссөн байна.

3. Улсын хэмжээнд 442 компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 88.5 хувь буюу 391 нь УБ хотод, 11.5 хувь буюу 51 нь Говь-Алтай, Увс, аймгуудаас бусад орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

4. Тайлант хугацаанд ББСБ-уудын нийт актив 581.9 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 2.99 хувьтай, зээлийн өрийн үлдэгдэл 383.4 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.26 хувьтай, эзэмшигчдийн өмч 393.1 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 15.78 хувьтай, дүрмийн сан 298.3 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 53.46 хувьтай тус тус тэнцэж байна.

5. ББСБ-уудын зарим үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 91.9 тэрбум төгрөгөөр буюу 18.7 хувиар, нийт активт эзлэх зээлийн хэмжээ 89.4 тэрбум төгрөгөөр буюу 30.4 хувиар, эзэмшигчдийн өмч 91.8 тэрбум төгрөгөөр буюу 30.5 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 63.9 мянган төгрөгөөр буюу 27.3 хувиар тус тус өссөн байна.

6. Тайлант үед салбарын активын өгөөж 6.4 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 9.5 хувь байгаа ба салбарын нийт хөрөнгө нь дотоодын нийт бүтээгдэхүүний 9.5 хувийг эзэлж байна.

7. ББСБ-уудын өр төлбөрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өр 7.0 тэрбум төгрөгөөр буюу 28.1 хувиар өссөн бол банк, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн өр 3.0 тэрбум төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

8. Тайлант үеийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, нийт зээлийн хэмжээ 89.4 тэрбум төгрөгөөр буюу 30.4 хувиар өссөн боловч /өмнөх оны энэ улирлын өсөлт 40.2 хувь байсан/ өсөлтийн хурдац нь буурах хандлагатай байна. Нийт 383.4 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагийн 88.7 хувь нь төгрөгийн, 11.2 хувь нь гадаад валютын зээл байна. Мөн нийт зээлийн багц өмнөх оны мөн үеэс 89.4 тэрбум төгрөгөөр буюу 30.4 хувиар өссөн бол нийт чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.1 тэрбум төгрөгөөр буюу 95.9 хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн хэмжээ, түүний дотор муу зээлийн хэмжээ 2 дахин буюу 8.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой зээлийн эрсдэлээс хамгаалах сан өмнөх оны мөн үеэс 10.9 тэрбум төгрөгөөр буюу 88.2 хувиар өссөн байна. Нийт зээлийн багцын 9.1 хувийг чанаргүй зээл эзэлж байгаа бөгөөд нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн байна.

9. ББСБ-ууд тайлант хугацаанд нийт 33,184,596.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.5 тэрбум төгрөгөөр буюу 24.3 хувиар өссөн байна. Нийт ББСБ-ын 76.0 хувь буюу 326 ББСБ 37,406,735.4 мянган төгрөгийн ашигтай, 18.8 хувь

буюу 83 ББСБ 4,222,139.0 мянган төгрөгийн алдагдалтай, 7.5 хувь буюу 33 ББСБ ашиг, алдагдалгүй ажилласан байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР